ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

---

Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: СНАГ-2024/5/НА-СТА-ТӨА**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2024 он | Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,<br>тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг<br>Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn<br><br>Аудитын менежер: Ц.Хосжаргал<br>Утас: 261885 Цахим хаяг: khosjargalts@audit.gov.mn<br><br>Аудитор: С.Отгонхорлоо<br>Утас: 261205 Цахим хаяг: otgonkhorloos@audit.gov.mn<br><br>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Эс Жи Эм Ди -Аудит ХХК-ийн захирал Д.Эхбаяр<br>Утас: 99116948<br>Цахим хаяг: ekhbayar@sgmd-audit.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.03.15 № 07/720

танай ____________-ны № ____________-т

УЛААНБААТАР ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Р.ДАГДАН ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, гүйцэтгэлийг Компанийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, заврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн дараах залруулагдаагүй алдаа, зөрчил тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна. Үүнд:

- Бараа материалын үлдэгдэлд тайлант онд хөдөлгөөн ороогүй 688.7 сая төгрөгийн бараа бүртгэлтэй;
- Цахилгаан эрчим хүч хэрэглэгч байгууллагаас авах авлагын үлдэгдэл нийт 18,896.1 сая төгрөгөөс 2,300.6 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн акт үйлдэж баталгаажуулаагүй;
- Авто зам доогуур кабель буудаж, нүх гаргах 180.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын тендерт шалгарсан Шинэ зам титэм ХХК-аас, Түгээх үйл ажиллагааны ажлын зохион байгуулалт, хүний нөөц, машин механизмын цахим хяналтын систем гүйцэтгэх 115.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын тендерт шалгарсан Өнө тэгш ХХК-аас тус тус гүйцэтгэлийн баталгаа аваагүй, гэрээ байгуулсан;
- Гэрэл цахилгаангүй айл өрхийн цахилгаан хангамж сайжруулах ажил /төсөвт өртөг 500.0 сая төгрөг/-д шалгарсан Жи Паур ХХК нь тендерийн баримт бичигт заасны

дагуу 2022 оны аудит хийгдсэн санхүүгийн тайланг ирүүлээгүй, Кабель засварын төвд шаардлагатай тусгай зориулалтын багаж /төсөвт өртөг 331.8 сая төгрөг/ худалдан авах тендерт шалгарсан Русс вууд ХХК нь тендерийн өгөгдлийн хүснэгтэд заасан ажлын туршлага, гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар, бараа хүлээлцсэн акт, протоколыг бүрэн ирүүлээгүй компаниудыг шалгаруулж, гэрээ байгуулсан.

зэрэг зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3, 27.1, 27.4, 43 дугаар зүйлийн 43.4, 43.4.1, 43.4.2, 46.1.2 гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд Эрчим хүчний зохицуулах хорооноос тус компанийн цахилгаан түгээлтийн алдагдлыг 13.66 хувиар баталсныг компани 11.65 хувь хүртэл бууруулж, цахилгаан түгээлтийн алдагдал бууруулснаар бүрдүүлсэн 14,500.0 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын өгөөж хэлбэрээр тарифт тусган, ухаалаг тоолуурын систем нэвтрүүлэх төслийн эхний шатыг хэрэгжүүлж эхэлсэн байна. Төслийн эхний шат хэрэгжснээр цахилгаан түгээлтийн алдагдал өндөртэй Баянзүрх, Сонгинохайрхан дүүргийн хэрэглэгчдэд 130 гаруй мянган ухаалаг тоолуур суурилуулахаар төлөвлөжээ.

**Аудитын гол асуудал**

Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирлын шийдвэрээр эргэц удаан, насжилт өндөртэй нийт 822.4 сая төгрөгийн бараа материалыг ашиглах, боломжит үнээр борлуулах ажлыг эхлүүлсэн байна.

Засгийн газрын 2017 оны 199 дүгээр тогтоолын хавсралт “Гэр хорооллын өрхөд цахилгаан эрчим хүчний тарифын хөнгөлөлт үзүүлэх журам”-ын дагуу гэр хорооллын хэрэглэгчдэд 20,564.4 сая төгрөгийн шөнийн тарифын хөнгөлөлт үзүүлж, уг хөнгөлөлтөд шаардлагатай эх үүсвэрийг улсын төсвөөс бүрэн санхүүжүүлсэн байна. Мөн өмнөх оны шөнийн тарифын хөнгөлөлтийн хуримтлагдсан өр төлбөр 6,206.8 сая төгрөгийг улсын төсвөөс төлж барагдуулжээ.

**Бусад асуудлын хэсэг**

Компанийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 254 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэл 98.2 хувьтай гэж тайлагнасан байна.
Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх болович үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

АТА9693 9006109
9023030583

Z:\Yawsan_Bichig\2024\0315 SNAG-31.Docx

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | ҮЗҮҮЛЭЛТ | 2022 оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **1** | **ХӨРӨНГӨ** | | |
| **1.1** | **Эргэлтийн хөрөнгө** | | |
| 1.1.1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө | 1,642,866,573.85 | 2,981,975,970.97 |
| 1.1.2 | Дансны авлага | 53,397,891,346.85 | 48,289,843,581.23 |
| 1.1.3 | Татвар, НДШ-ийн авлага | 820,608,096.98 | 695,357,958.60 |
| 1.1.4 | Бусад авлага | 1,776,385,509.31 | 2,043,564,300.66 |
| 1.1.6 | Бараа материал | 13,180,719,993.08 | 12,349,434,327.55 |
| 1.1.7 | Урьдчилж төлсөн зардал/тооцоо | 51,037,469.98 | 47,819,822.80 |
| **1.1.11** | **Эргэлтийн хөрөнгийн дүн** | **70,869,508,990.05** | **66,407,995,961.81** |
| **1.2** | **Эргэлтийн бус хөрөнгө** | | - |
| 1.2.1 | Үндсэн хөрөнгө | 323,625,150,699.49 | 343,583,589,542.91 |
| 1.2.2 | Биет бус хөрөнгө | 3,898,137,604.82 | 4,100,912,011.31 |
| 1.2.8 | Бусад эргэлтийн бус хөрөнгө | 433,448,603.35 | 375,655,456.24 |
| **1.2.10** | **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | **327,956,736,907.66** | **348,060,157,010.46** |
| **1.3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **398,826,245,897.71** | **414,468,152,972.26** |
| **62** | **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ** | | - |
| **2.1** | **Өр төлбөр** | | - |
| **2.1.1** | **Богино хугацаат өр төлбөр** | | - |
| 2.1.1.1 | Дансны өглөг | 42,238,808,113.85 | 32,228,102,681.77 |
| 2.1.1.2 | Цалингийн өглөг | 4,262,546,271.22 | 4,896,926,712.82 |
| 2.1.1.3 | Татварын өр | 2,114,650,475.46 | 2,097,578,611.01 |
| 2.1.1.5 | Богино хугацаат зээл | - | 3,312,761,541.11 |
| 2.1.1.8 | Урьдчилж орсон орлого | 2,196,038,455.03 | 1,986,744,426.54 |
| 2.1.1.10 | Бусад богино хугацаат өр төлбөр | 740,444,927.62 | 759,847,263.19 |
| **2.1.1.13** | **Богино хугацаат өр төлбөрийн дүн** | **51,552,488,243.18** | **45,281,961,236.44** |
| **2.1.2** | **Урт хугацаат өр төлбөр** | | - |
| 2.1.2.1 | Урт хугацаат зээл | 26,162,654,734.70 | 21,453,878,720.16 |
| 2.1.2.2 | Нөөц /өр төлбөр/ | - | - |
| 2.1.2.3 | Хойшлогдсон татварын өр | 4,584,156,259.08 | 4,816,208,063.94 |
| 2.1.2.4 | Бусад урт хугацаат өр төлбөр | 28,252,696,480.98 | 49,153,061,439.19 |
| 2.1.2.5 | | | - |
| **2.1.2.6** | **Урт хугацаат өр төлбөрийн дүн** | **58,999,507,474.76** | **75,423,148,223.29** |
| **2.2** | **Өр төлбөрийн нийт дүн** | **110,551,995,717.94** | **120,705,109,459.73** |
| **2.3** | **Эздийн өмч** | | - |
| 2.3.1 | Өмч: - төрийн | 210,661,703,243.86 | 239,360,638,644.76 |
| 2.3.6 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 42,131,594,700.88 | 40,954,606,964.40 |
| 2.3.8 | Эздийн өмчийн бусад хэсэг | 32,934,311,024.09 | 10,209,210,443.49 |
| 2.3.9 | Хуримтлагдсан ашиг | 2,546,641,210.94 | 3,238,587,459.88 |
| **2.3.11** | **Эздийн өмчийн дүн** | **288,274,250,179.77** | **293,763,043,512.53** |
| **2.4** | **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН** | **398,826,245,897.71** | **414,468,152,972.26** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | ҮЗҮҮЛЭЛТ | 2022 оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **1** | **Борлуулалтын орлого (цэвэр)** | **608,764,748,941.44** | **744,542,411,040.28** |
| | ЦЭХ-ний орлого | 541,607,335,741.44 | 646,272,154,440.28 |
| | Түгээх үйлчилгээний орлого | 67,157,413,200.00 | 98,270,256,600.00 |
| **2** | Борлуулалтын өртөг | **573,377,774,556.10** | **697,851,857,863.00** |
| | ХАЦЭХ | 523,645,028,904.28 | 638,430,445,427.52 |
| | Түгээх үйл ажиллагааны зардал | 49,732,745,651.82 | 59,421,412,435.48 |
| **3** | **Нийт ашиг (алдагдал)** | **35,386,974,385.34** | **46,690,553,177.28** |
| 4 | Түрээсийн орлого | 45,989,454.54 | 77,697,955.05 |
| 5 | Хүүний орлого | - | 12,045,280.26 |
| 6 | Ногдол ашгийн орлого | - | - |
| 7 | Эрхийн шимтгэлийн орлого | - | - |
| 8 | Бусад орлого | 14,317,020,144.95 | 19,086,478,623.41 |
| 9 | Борлуулалт, маркетингийн зардал | 29,619,266,313.70 | 36,084,534,001.29 |
| 10 | Ерөнхий ба удирдлагын зардал | 13,201,972,810.86 | 16,395,159,063.43 |
| 11 | Санхүүгийн зардал | 430,409,019.00 | 498,616,660.77 |
| 12 | Бусад зардал | 9,677,014,853.65 | 11,755,061,085.10 |
| 13 | Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз) | | - |
| 14 | Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | 6,559,090.91 | (717,401,250.17) |
| 15 | Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | | - |
| 16 | Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз) | | - |
| 17 | Бусад ашиг (алдагдал) | | - |
| **18** | **Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)** | **(3,172,119,921.47)** | **416,002,975.24** |
| 19 | Орлогын татварын зардал | (691,769,958.83) | 410,746,320.50 |
| **20** | **Татварын дараах ашиг (алдагдал)** | **(2,480,349,962.64)** | **5,256,654.74** |
| 21 | Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал) | | - |
| **22** | **Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)** | **(2,480,349,962.64)** | **5,256,654.74** |
| **23** | **Бусад дэлгэрэнгүй орлого** | | - |
| | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү | | - |
| | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | - |
| | Бусад олз (гарз) | | - |
| **24** | **Орлогын нийт дүн** | **-** | - |
| **25** | **Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)** | | - |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | ҮЗҮҮЛЭЛТ | 2022 оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **1** | **Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| 1.1 | Мөнгөн орлогын дүн (+) | **669,621,715,265.21** | **784,995,708,276.41** |
| | Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого | 588,548,119,954.17 | 675,359,471,780.43 |
| | Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого | - | - |
| | Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө | 247,274,899.00 | 274,402,700.33 |
| | Буцаан авсан албан татвар | - | - |
| | Татаас, санхүүжилтийн орлого | - | - |
| | Бусад мөнгөн орлого | 80,826,320,412.04 | 109,361,833,795.65 |
| 1.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | **659,972,365,415.77** | **775,035,298,341.02** |
| | Ажиллагчдад төлсөн | 40,980,002,091.65 | 50,498,921,024.78 |
| | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 11,982,849,936.72 | 15,543,162,198.41 |
| | Бараа материал худалдан авахад төлсөн | 17,286,328,368.82 | 19,390,272,888.23 |
| | Ашиглалтын зардалд төлсөн | 1,733,076,947.94 | 2,157,806,464.65 |
| | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн | 2,010,580,376.00 | 3,439,105,798.92 |
| | Хүүний төлбөрт төлсөн | 545,155,914.39 | 504,034,821.69 |
| | Татварын байгууллагад төлсөн | 9,314,736,479.84 | 14,427,041,892.65 |
| | Даатгалын төлбөрт төлсөн | 116,468,015.00 | 97,672,062.00 |
| | Бусад мөнгөн зарлага | 576,003,167,285.41 | 668,977,281,189.69 |
| **1.3** | **Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | 9,649,349,849.44 | **9,960,409,935.39** |
| 2 | Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | **-** | **-** |
| 2.1 | Мөнгөн орлогын дүн (+) | **7,250,000.00** | **44,392,280.26** |
| | Үндсэн хөрөнгө борлуулсны орлого | 7,250,000.00 | 32,347,000.00 |
| | Биет бус хөрөнгө борлуулсны орлого | - | - |
| | Хөрөнгө оруулалт борлуулсны орлого | - | - |
| | Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого | - | - |
| | Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт | - | - |
| | Хүлээн авсан хүүний орлого | - | 12,045,280.26 |
| | Хүлээн авсан ногдол ашиг | - | - |
| | | | |
| 2.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | **6,970,196,117.09** | **9,110,236,197.23** |
| | Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 6,970,196,117.09 | 9,110,236,197.23 |
| | Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | - | - |
| | Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн | - | - |
| | Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | - | - |
| | Бусдад олгосон зээл болон урьдчилгаа | - | - |
| **2.3** | **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **(6,962,946,117.09)** | **(9,065,843,916.97)** |

| | | | |
|---|---|---|---|
| **3** | **Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| 3.1 | Мөнгөн орлогын дүн (+) | **-** | **2,800,000,000.00** |
| | Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | - | 2,800,000,000.00 |
| | Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | **-** | **-** |
| | Төрөл бүрийн хандив | - | - |
| 3.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | **3,530,437,204.42** | **2,355,456,621.30** |
| | Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө | 3,530,437,204.42 | 2,355,456,621.30 |
| | Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн | - | |
| | Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн | - | |
| | Төлсөн ногдол ашиг | - | |
| **3.3** | **Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **(3,530,437,204.42)** | **444,543,378.70** |
| **4** | **Валютын ханшийн зөрүү** | | |
| **5** | **Бүх цэвэр мөнгөн гүйлгээ** | **(844,033,472.07)** | **1,339,109,397.12** |
| **6** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **2,486,900,045.92** | **1,642,866,573.85** |
| **6** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **1,642,866,573.85** | **2,981,975,970.97** |

### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмч | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | Эздийн өмчийн бусад хэсэг | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **2021 оны 12-р сары 31-ний үлдэгдэл** | **179,737,275,206.59** | **46,363,120,605.48** | **33,043,804,537.27** | **(4,030,738,385.05)** | **255,113,461,964.29** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | - | - | | (1,022,672,294.41) | **(1,022,672,294.41)** |
| **Залруулсан үлдэгдэл** | **179,737,275,206.59** | **46,363,120,605.48** | **33,043,804,537.27** | **(5,053,410,679.46)** | **254,090,789,669.88** |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | | | | (2,480,349,962.64) | **(2,480,349,962.64)** |
| Өмчид гарсан өөрчлөлт | 30,924,428,037.27 | | (109,493,513.18) | | **30,814,934,524.09** |
| Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | | (4,231,525,904.60) | | 10,080,401,853.04 | **5,848,875,948.44** |
| **2022 оны 12-р сары 31-ний үлдэгдэл** | **210,661,703,243.86** | **42,131,594,700.88** | **32,934,311,024.09** | **2,546,641,210.94** | **288,274,250,179.77** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | | | | 686,689,594.2 | 686,689,594.2 |
| **Залруулсан үлдэгдэл** | **210,661,703,243.86** | **42,131,594,700.88** | **32,934,311,024.09** | **3,233,330,805.14** | **288,960,939,773.97** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | | | | 5,256,654.74 | 5,256,654.74 |
| Өмчид гарсан өөрчлөлт | 28,698,935,400.90 | | (22,725,100,580.60) | | **5,973,834,820.30** |
| Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | | (1,176,987,736.48) | | | (1,176,987,736.48) |
| **2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | **239,360,638,644.76** | **40,954,606,964.40** | **10,209,210,443.49** | **3,238,587,459.88** | **293,763,043,512.53** |

## 2.5 Техник, Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

| д/д | Үзүүлэлтүүд | хэмжих нэгж | 2022 оны гүйцэтгэл | 2023 он | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | төлөвлөгөө | гүйцэтгэл | биетээр | хувиар |
| | А | 1 | 3 | 4 | 5 | 6=5-4 | 7=5/4 |
| 1 | Худалдаж авах цахилгаан | сая.кВтц | 3,727.50 | 3,844.00 | 3,850.20 | 6.20 | 100.2% |
| | ЦЭХ-ний алдагдал: хувиар | хувь | 12.20% | 12.20% | 11.65% | (0.01) | 95.5% |
| | биетээр | сая.кВтц | 453.8 | 468.97 | 448.41 | (20.56) | 95.6% |
| | Борлуулах ЦЭХ | сая.кВтц | 3,273.70 | 3,375.03 | 3,401.77 | 26.74 | 100.8% |
| 2 | **Нийт орлого** | **сая.төг** | **623,134.3** | **740,361.6** | **763,748.0** | **23,386.4** | **103.2%** |
| | ЦЭХ-ийн орлого, үүнээс | сая.төг | 541,607.3 | 646,600.0 | 646,272.2 | -327.8 | 99.9% |
| | Түгээх үйл ажиллагааны | | 67,157.4 | 79,419.1 | 98,270.3 | 18,851.2 | 123.7% |
| | Үндсэн бус үйл ажиллагааны орлого | сая.төг | 14,369.6 | 14,342.5 | 19,205.6 | 4,863.1 | 133.9% |
| 3 | **Нийт зардал, үүнээс:** | **сая.төг** | **626,306.4** | **746,127.7** | **763,332.0** | **17,204.3** | **102.3%** |
| | ЦЭХ-ний төлбөр | сая.төг | 523,645.0 | 627,340.7 | 638,430.4 | 11,089.7 | 101.8% |
| | Үйл ажиллагааны зардал | сая.төг | 92,984.4 | 106,189.1 | 112,399.7 | 6,210.6 | 105.8% |
| | Үндсэн бус үйл ажиллагааны зардал | сая.төг | 9,677.0 | 12,597.9 | 12,501.9 | -96.0 | 99.2% |
| | Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал | сая.төг | 23,949.1 | 22,773.4 | 26,582.6 | 13,984.7 | 116.7% |
| 4 | Татварын өмнөх ашиг /алдагдал/ | сая.төг | -3,172.1 | **-5,766.1** | **416.0** | **6,182.1** | **-7.2%** |
| | Орлогын татвар | сая.төг | 691.8 | | 410.7 | 410.7 | |
| 5 | **Цэвэр ашиг, алдагдал** | **сая.төг** | **-2,480.3** | -5,766.1 | 5.2 | 5,771.3 | -0.1% |
| 6 | Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал | | 1.0 | 1.0 | 1.0 | 0.0 | 99.0% |
| 7 | **Нийт авлага:** | **сая.төг** | **55,994.9** | **48,446.6** | **51,028.8** | **2,582.2** | **105.3%** |
| | ЦЭХ-ний авлага | сая.төг | 53,397.9 | 38,985.8 | 48,289.8 | 9,304.0 | 123.9% |
| | Бусад авлага | сая.төг | 2,597.0 | 9,460.8 | 2,738.9 | -6,721.9 | 29.0% |
| 8 | **Нийт өр төлбөр:** | **сая.төг** | **110,779.9** | **99,798.4** | **120,705.1** | **20,906.7** | **120.9%** |
| | Богино хугацаат өр | сая.төг | 51,780.4 | 39.629.3 | 45,282.0 | 5,652.0 | 114.3% |
| | Урт хугацаат өр төлбөр | сая.төг | 58,999.5 | 60,169.1 | 75,423.1 | 15,253.9 | 125.4% |
| 9 | Ажиллагсадын тоо | хүн | 1,940.0 | 1,940.0 | 1,940.0 | 0.0 | 100.0% |
| 10 | Цалингийн сан | сая.төг | 41,871.2 | 52,618.4 | 51,736.5 | -881.9 | 98.3% |
| 11 | Цахилгаан тасалдын дундаж хугацаа Исайди | Минут | 920.95 | 1,215.00 | 917.76 | -297.24 | 75.5 |
| 11 | **Хөрөнгө оруулалт, их засвар** | **сая. Төг** | **16,821.4** | **87,579.7** | **49,618.3** | **-37,961.4** | **56.7%** |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 7,462.3 сая төгрөгийн 6 алдаа[1] илэрснээс аудитын явцад залруулсан.

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл** /мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан маягтын дагуу тайлант хугацааны тодруулга 22- Холбоотой талуудын тодруулгын 22.1, 22.2, 22.3, 23-Болзошгүй хөрөнгө ба өр төлбөр, 24- Тайлагналын үеийн дараах үйл явдлыг бэлтгээгүй. | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| Бараа материалын орлогын бүртгэлд 85.0 сая төгрөгийн бараа нь бэлтгэн нийлүүлэгчээс ирүүлсэн зарлагын баримтаар 93.5 сая төгрөг буюу 8.5 сая төгрөгөөр дутуу бүртгэсэн. | 1 | 8,500.0 | | | | | 1 | 8,500.0 | | | | |
| Санхүүгийн тайлан дахь хойшлогдсон татварын өглөг 4,584.1 сая төгрөгийн эхний үлдэгдлийг 6,832.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж Юнитакс ТИН ХХК-ийн "Tax Acc 1.0" программ ашиглан тооцоолж 11,416.9 сая төгрөг болгож залруулж тайлагнасан байна. Тус залруулсан 6,832.9 сая төгрөгийн тооцоолол нь нотлогдохгүй, аргачлал буруу байна. | 1 | 6,832,873.0 | | | | | 1 | 6,832,873.0 | | | | |

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Санхүүгийн тайланд НДШ-ийн авлагын үлдэгдлийг нийгмийн даатгалын байгууллагад тайлагнасан дүнгээс 16.4 сая төгрөгөөр дутуу илэрхийлсэн. | 1 | 16,424.4 | | | | | 1 | 16,424.4 | | | | |
| Хөрөнгө орлогод бүртгэх ТӨБЗГ-ын тогтоолд тусгагдсан дүнгээс 380.5 сая төгрөгөөр үндсэн хөрөнгийг орлогод дутуу бүртгэсэн. | 1 | 380,541.7 | | | | | 1 | 380,541.7 | | | | |
| Тайлант хугацааны НӨАТ-ын тайлангаарх болон санхүүгийн тайлангаарх борлуулалтын орлогыг 195.1 сая төгрөгийн зөрүүтэй илэрхийлж, НӨАТ-ын өглөгийн эцсийн үлдэгдэл 224.0 сая төгрөгөөр дутуу тусгасан байна. | 1 | 223,999.6 | | | | | 1 | 223,999.6 | | | | |
| **Дүн** | **6** | **7,462,338.7** | | | | | **6** | **7,462,338.7** | | | | |

Аудитаар нийт 4,413.5 сая төгрөгийн 7 зөрчил[2] илэрснээс, 1.5 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 3,425.3 сая төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлж, 986.7 сая төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл** /мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Ашиглалт засварын Баруун төв нь 2020 онд үүссэн 18.5 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй байна. | 1 | 18,500.0 | | | | | 1 | 18,500.0 | | | | |
| Цахилгаан эрчим хүч хэрэглэгч байгууллагаас авах авлага нийт 20,438.3 сая төгрөг байгаагаас 2,300.6 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн акт үйлдэж баталгаажуулаагүй байна. | 1 | 2,300,600.0 | | | 1 | 2,300,600.0 | | | | | | |
| Тайлант онд хөдөлгөөн ороогүй үлдэгдэлтэй 688,749.8 мянган төгрөгийн бараа материал байна. | 1 | 688,749.8 | | | | | 1 | 688,749.8 | | | | |
| Жилийн эцсийн тооллогын комисс нь тооллогыг чанартай гүйцэтгээгүй, тооллогын комисс тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулсан холбогдох акт баримт бичигт гарын үсгийн бүрдэл дутуу, үндсэн хөрөнгийн “Компьютер, дагалдах хэрэгсэл” төрөлд тоологдсон 279,417.4 мянган төгрөгийн хөрөнгийг эзэмшиж байгаа албан хаагчдын эд хөрөнгө ашиглалтын бүртгэл гарын үсгээр баталгаажуулаагүй байна. | 1 | 279,417.4 | | | | | 1 | 279,417.4 | | | | |
| Тендерийн баримт бичигт тусгасан шалгуур хангаагүй хуулийн этгээдийг сонгон шалгаруулсан байна. Үүнд:<br>1.Гэрэл цахилгаангүй айл өрхийн цахилгаан хангамж сайжруулах ажил /төсөвт өртөг-500.0 сая төгрөг/-д шалгарсан Жи Паур ХХК нь тендерийн баримт бичгийн Тендерийн өгөгдлийн хүснэгтэд “2 жил буюу 2021, 2022 оны аудитлагдсан санхүүгийн тайлан ирүүлнэ” гэж заасны дагуу 2022 оны аудитлагдсан санхүүгийн тайланг ирүүлээгүй байна. | 1 | 831,842.1 | | | 1 | 831,842.1 | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2. Кабель засварын төвд шаардлагатай тусгай зориулалтын багаж /төсөвт өртөг-331.8 сая төгрөг/ худалдан авах тендерт шалгарсан Русс вүүд ХХК нь тендерийн өгөгдлийн хүснэгтэд заасан “ижил төстэй гэрээний туршлага: 2021, 2022 онуудын аль нэг жилд төсөвт өртөгийн 50%-иас багагүй ижил төстэй ажил гүйцэтгэсэн байх. /Гэрээний хуулбар, бараа хүлээлцсэн акт, протоколын хамтаар ирүүлнэ./, ижил төстэй ажилд санал болгосон бараа болон түүнтэй дүйцэхүйц бараа эсвэл цахилгааны тоног төхөөрөмж нийлүүлсэн туршлагыг тооцно. ТШЗ 18.6.4-ын дагуу ирүүлэх” гэсэн шаардлагын дагуу материалыг бүрэн ирүүлээгүй байна. | | | | | | | | | | | | |
| Авто зам доогуур кабель буудаж, нүх гаргах 180.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын тендерт шалгарсан Шинэ зам титэм ХХК-аас, “Түгээх үйл ажиллагааны ажлын зохион байгуулалт, хүний нөөц, машин механизмын цахим хяналтын систем гүйцэтгэх 115.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын тендерт шалгарсан Өнө тэгш ХХК-аас тус тус гүйцэтгэлийн баталгаа аваагүй, гэрээ байгуулсан байна. | 1 | 292,895.0 | | | 1 | 292,895.0 | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| "Авто зам доогуур кабель буудаж, нүх гаргах ажил" тендерийн баримт бичигт гэрээний үнийн дүнгийн 3%-тай тэнцэх гүйцэтгэлийн баталгаа ирүүлэхийг тусгасан боловч шалгарсан Шинэ зам титэм ХХК-аас гүйцэтгэлийн баталгаа аваагүй, "Түгээх үйл ажиллагааны ажлын зохион байгуулалт, хүний нөөц, машин механизмын цахим хяналтын систем" тендерийн баримт бичигт гэрээний үнийн дүнгийн 3%-тай тэнцэх гүйцэтгэлийн баталгаа ирүүлэхийг тусгасан боловч шалгарсан Өнө тэгш ХХК-нь гүйцэтгэлийн баталгаа ирүүлээгүй байгаа зэрэг нь тендерийн баталгааг Сангийн яаманд төвлөрүүлэх үндэслэл болсон бөгөөд төвлөрүүлээгүй байна. | 1 | 1,464.5 | 1 | 1,464.50 | | | | | | | | |
| **Дүн** | **7** | **4,413,468.8** | **1** | **1,464.50** | **3** | **3,425,337.1** | **3** | **986,667.2** | **-** | **-** | **-** | - |

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 1,270.2 сая төгрөгийн 3.зөрчил илэрснээс 525.4 сая төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 744.8 сая төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** /мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансны цахим хуудсан 1 удаагийн 744, 836. 4 мянган төгрөгийн мэдээллийг хуулийн хугацаанаас нь хоцроож байршуулсан байна. | 1 | 744,836.4 | | | | | 1 | 744,836.4 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Дүн** | **1** | **744,836.4** | - | **-** | **-** | **-** | **1** | **744,836.4** |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Тайлант онд ХАА-ны төлөвлөгөөнд 1,083.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Реклоузер худалдан авахаар баталсан ба төсөвт өртгийг тооцоолсон үндэслэл байхгүй. Уг тендерт нийлүүлэгчээр шалгарсан Дөрвөлжин интернэйшнл ХХК нь 1,078.9 сая төгрөгийн гэрээ байгуулсан ба гэрээний хугацааг сунгаж 2023.06.05-ны өдөр гэрээг дүгнэн 1,078.9 сая төгрөгийн барааг нийлүүлсэн, хүлээлгэн өгсөн акт үйлдэн гарын үсгээр баталгаажуулсан байна. Гэвч бараа материалыг хүлээлгэн өгсөн анхан шатны баримтаар 1,059.7 сая төгрөгийн барааг 2023.05.25-ны өдөр, 5.6 сая төгрөгийн барааг 2023.10.12-ны өдөр, 13.6 сая төгрөгийн барааг 2023.10.02-ны өдөр хүлээлгэн өгсөн байна. | 1 | 19,200.0 | | | 1 | 19,200.0 | | |
| Тайлант онд зохион байгуулсан 5 тендерийн нийт 506,200.0 мянган төгрөгийн гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнүүдийн мэдээлэлийг www.tender.gov.mn- цахим системд байршуулаагүй мэдээлэзгүй байна. | 1 | 506,200.0 | | | 1 | 506,200.0 | | |
| **Дүн** | **2** | **525,400.0** | **-** | **-** | **2** | **525,400.0** | **-** | **-** |
| **Нийт дүн** | **3** | **1,270,236.4** | **-** | **-** | **2** | **525,400.0** | **1** | **744,836.4** |